

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ**

№ 13/380

НШУС

2012

**СЭТГҮҮЛ ЗҮЙН СУДЛААЧ, НИЙТЛЭЛЧ Л.НОРОВСҮРЭН**

Т.Баасансүрэн\*

\* «Улаанбаатар-Эрдэм-Оюу» дээд сургуулийн Сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч, доктор, профессор

**Л.** Норовсүрэн бол Монголын сэтгүүл зүйн нэрд гарсан том судлаач гэдгийг юуны өмнө онцлон тэмдэглэж хэлэхийг хүсч байна. Тэрээр «Сонинь бичлэгийн төрөл, зүйл» (1994), «Редакторлах зүйн онол, дадлага» (1996), «Монголын сэтгүүл зүйн өмнөх үзэгдлүүд» (1999), «Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм» I, II, III боть (2000, 2001, 2003), «Ярилцлага бичих арга зүй» (М.Зулькафильтэй хамт, 2001), «Иргэний сэтгүүл зүй ба Монголын уламжлал» (2001), «Монголын нийтлэл» I, II, III дэвтэр (2004, 2005, 2007), «Иргэний сэтгүүл зүй» (Х.Энхтуяатай хамт, 2005), «Монголын сэтгүүл зүйн судалгааны бүтээлийн ном зүйн лавламж» (Г.Өнөрбаяртай хамт, 2005), «Ложоогийн Ширчин: намтар, уран бүтээлийн товчоон» (2006), «Хянан найруулах ухаан» (2008), «Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл» (2008), «Телевизийн сэтгүүл зүй» (Н.Ариунзаяатай хамт, 2009), «Радио сэтгүүл зүй» (Н.Ариунзаяатай хамт, 2010), «Гурван гүрэнд зорчсон тэмдэглэл» (2011), «Монгол хуучин сонин, сэтгүүлийн товч лавлах» (2012), «ХХ зууны эхэн үеийн монгол сэтгүүлчид» (2012), «Фото сэтгүүл зүй» (2012) зэрэг нэг сэдэвт зохиол, сурах бичиг, гарын

авлага 38-ыг бичиж, бусдын 23 номыг редакторласан байна. Мөн эрдэм шинжилгээний өгүүлэл 52-ыг нийтлүүлж, 26 илтгэлийг сургууль, улс, олон улсын хэмжээний хуралд тавьж хэлэлцүүлсний зарим нь ОХУ, БНХАУ-д хэвлэгджээ.

Түүнчлэн «Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм»-ын турван боть зохиол нь 2006 онд БНХАУ-д хэвлэгдэж, тус улсын монгол хэлт үндэстнүүдийн их, дээд сургуулиудын багш, оюутны гарын авлага болсон бөгөөд Монголоос сэтгүүл зүйн чиглэлээр гадаадад хэвлэгдсэн анхны суурь судалгааны бүтээл болсон юм. Түүний «Монголын нийтлэл» хэмээх турван боть зохиолыг ч мөн БНХАУ-д монгол бичгээр хэвлэжээ.

Л.Норовсүрэн сэтгүүлчийн ур чадвараа шавь нараа үлгэрлэдэг багш, уран бүтээлч гэдгийг хэлэх нь зүйтэй болов уу. Өнгөрсөн хугацаанд «Ус хөтөлсөн хүн» өгүүллэг, найрууллын эмхтгэл (1983), «Цэлмэг тэнгэрийн эзэд» (1986), «Модны хээ» (1988) зэрэг баримтат киноны зохиол, «Байгалийн хишгийг хүртэж сурцаа» (2000) зөвлөмжийн ном, «Бугатынхан» (1996), «Жарны түүхтэй жаргалтайн дэлгэр нутаг мину» (2006) түүхэн танилцуул-

ГЫН НОМУУД, «МУИС-50 жилд» фото альбом (1992) зэрэг бүтээл туурвиж, 1965 оноос өнөөг хүртэл төв, орон нутгийн сонин хэвлэлд бичлэгийн бүх төрөл зүйлээр 5000 орчим материал нийтлүүлжээ. «Газар бид хоёр», «Сэтгэлийн авиа» найрууллууд нь залуучуудын хэвлэлийн 50 жил, Ардын Хувьсгалын 60 жилийн ойгоор зарласан уран бүтээлийн уралдаануудад байр эзэлж байв. Чамбай сайн нийтлэл, гэрэл зураг бүтээсний учир Л.Норовсүрэн төвийн сонин, сэтгүүлийн оны шилдэг бичлэгийн болон уралдааны шагналыг 10 гаруй удаа авсан байна.

Л.Норовсүрэнгийн зүтгэл бүтээлийг төр засаг, мэргэжлийн уран бүтээлийн байгууллагаас үнэлж «Хэвлэл мэдээллийн тэргүүний ажилтан», «Боловсролын тэргүүний ажилтан», «Шинжлэх ухааны тэргүүний ажилтан» цол, тэмдэг олгож, МСЭ-ийн нэрэмжит шагнал, Ж.Цэвээний нэрэмжит сэтгүүл зүйн дээд шагнал хүртээжээ. Мөн төрийн дээд шагнал «Алтангадас» одонгоор шагнагдсан байна.

Л.Норовсүрэн 1996 онд «Монголын тогтмол хэвлэлийн бичлэгийн төрөл, зүйлийн онол-практикийн зарим асуудал» сэдвээр дэд доктор (Ph.D)-ын, 2004 онд «Монголын сэтгүүл зүйн онол, түүхийн тулгуур асуудлууд» сэдвээр шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэргийг тус тус хамгаалж, 1998 онд Эрдмийн зэрэг, цол олгох дээд комиссоос дэд профессорын цол хүртжээ. Тэрчлэн 2004 онд НШУС-ийн шилдэг багшаар шалгарч байв. Л.Норовсүрэн 2011 онд Монголын анхны хувийн хэвшлийн «Отгонтэнгэр» Их Сургуулийн «Хүндэт доктор» цол хүртсэн байна.

Монголын сэтгүүл зүйн өмнөх үзэгдлийг гүнзгийрүүлэн судлах, сэт-

гүүл зүйн анхдагчдыг тодруулах, сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйлийн онол, арга зүйг боловсруулах зэрэг асуудлаар түүний хийсэн бүтээл Монголын сэтгүүл зүйн онол-түүхийн судалгааг хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулсан юм.

Миний бодлоор Монголын сэтгүүл зүйн судлалын түүхэнд бүтээл туурвилаараа Гэндэнжамцын Дэлэгийн дараа нэр бичигдэх том эрдэмтэн судлаач бол Ломбын Норовсүрэн гэдэгт отхон ч эргэлзэхгүй байна. Л.Норовсүрэн нь өөрийн мэдлэг боловсрол, авьяас билиг, хүч хөдөлмөрийг Монголын сэтгүүл зүйн судлалд бүрэн зориулсан цөөхөн эрдэмтний нэг мөн.

“Монголын сэтгүүл зүйн шүүмж судлал: Сэтгүүл зүйн судлаач, нийтлэл Ломбын Норовсүрэн” номд өгүүлсэн бүхнээс доорх үндсэн дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

**Н**эг. Ломбын Норовсүрэн “Монголын хэвлэлийн сэтгүүл зүйн түүхэн тойм” (гурван боть), “Монголын нийтлэл” (гурван боть) хэмээх 150 гаруй хэвлэлийн хуудас зургаан боть бүтээл туурвиж, Монголын сэтгүүл зүйн судлалд жинтэй хувь нэмэр оруулжээ. Эдгээр бүтээлдээ Монголд сэтгүүл зүй үүсч хөгжсөн урт удаан хугацааны нарийн түвэгтэй үйл явц буюу барагцаалбал найман зууны туршид хуримтлагдсан манай аман утга зохиол дахь мэдээ мэдээллийн шинж чанартай элементүүдийг нухацтай судалж, сүүлийн зуун жилд Монголын тогтмол хэвлэл жинхэнэ утгаараа бүрэлдэн төлөвшсөн өвермөц онцлогийг товоилгон гаргасан байна. Үе үеийн сэтгүүлчдээс Монголын нийтлэлийг хөгжүүлэхэд оруулсан бодитой хувь нэмрийг баттай баримттайгаар дэлгэн үзүүлжээ. Ингэснээр Монголын нийтлэл, сэтгүүл зүйн хөгжил төлөвш-

лийг түүхэн үүднээс бүрэн хэмжээгээр хамруулж судалсан давтагдашгүй үнэт цувралыг бүтээж чадсан байна. Энэ бол манай сэтгүүл зүйн түүх, түүний судлалд оруулсан жинтэй хувь нэмэр мөн бөгөөд академич Х.Сампилдэн-дэвийн онож зүйрлэсэнчлэн Монголын соёлын түүх бичлэгт мөнхөд гэрэлтэн улдэх эрдэнийн

шигтгээ мөн. Доктор, профессор Л. Норовсүрэн дээрх цувралаараа Монголын сэтгүүл зүйн судлалд хэд хэдэн шинэ үгийг хэлсэн нь онцгой чухал юм. Тухайлбал:

А) Монголын орчин цагийн нийтлэлийн эх үүсвэр нь монгол ардын аман зохиол, үлгэр туульс, домог, ерөөл, магтаал,

дуу, зүйр цэцэн үг мөн гэж үзээд тэдгээрийг хөдөлшгүй жишээ баримтаар итгэл үнэмшилтэйгээр баталж захидал, заргын бичиг гэх мэт утга зохиолын хэлбэрүүд нь нийтлэл үүсэхэд шууд нөлөөлсөн гэдэг дүгнэлтийг анх удаа хийжээ. Монголын нийтлэлийн хөгжлийн энэхүү зүй тогтолыг урьд нь хэн ч ингэж тодорхойлон гаргаж ирээгүй юм.

Б) Монголд тогтмол хэвлэл үүсч хөгжсөн түүхийг шинэ өнцгөөс харж "Шинэ толь хэмээх бичиг", "Нийслэл хүрээний сонин бичиг", 1921 оны ардын хувьсгалын ухуулах хуудсууд, "Монголын үнэн", "Ардын үндэсний эрх", "Монгол ардын үндэсний соёлын зам" зэрэг олон сонин хэвлэлийн нийтлэлд задлан шинжилгээ хийх замаар нийтлэлийнх нь агуулга, ач холбогдлыг

судалж, Монголын сэтгүүл зүйг үндэслэгч нь Жамсраны Цэвээн мөн гэдэг дүгнэлтийг зоригтойгоор хийж чаджээ. Монголын сэтгүүл зүйн түүхэнд эрдэмт хүмүүн Жамсраны Цэвээний гүйцэтгэсэн үүрэг ролийг манай сэтгүүл зүйн судлаачид ойлгож мэдэрч, түүний сэтгүүлчийн үйл ажиллагааг янз бүрийн өнцгөөс үнэлж дүгнэж байсан ч Монголын сэтгүүл зүйг үндэслэгч гэж хэлж байгаагүй, саяхныг хүртэл маргаж мэтгэлцэж ирсэн юм. Үүнд нэг талаас социализмын үеийн ангич, намч хэвлэлийн бодлого саад totgor учруулж байсан нь ойлгомжтой ч, негее талаас

Монголын сэтгүүл зүйн судлал, түүний төлөөлөгчид уг асуудалд шинжлэх ухаанчаар хандаж чадаагүйтэй шууд холбоотой.

Хоёр. Доктор, профессор Л.Норовсүрэн өөрийн бичиж нийтийн хүртээл болгосон "Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл" сурх бичгээрээ энэ чиглэлийн ойлголтыг нэг мөр болгоход жинтэй хувь нэмэр оруулсан байна. Судлаач энэ номдоо сэтгүүл зүйн бичлэгийн цогцыг төрөл, зүйл, хэлбэрээр нь системчлэн судалж, бүтэц, байгууламжийг нь нарийвчлан задлан шинжилж, тус бүрээр нь оновчтой тодорхойлсон байна. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйлийн талаар гадаад, дотоодын судлаачдын цөөнгүй ном зохиол гарсан, Монголын сэтгүүлчид, сэтгүүл зүйн судлаачид энэ талаар баагүй

«  
Миний бодлоор Монголын сэтгүүл зүйн судлалын түүхэнд бүтээл туурвилаараа Гэндэнэсамцын Дэлэгийн дараа нэр бичигдэх том эрдэмтэн судлаач бол Ломбын Норовсүрэн гэдэгт огтхон ч эргэлзэхгүй байна. Л.Норовсүрэн нь өөрийн мэдлэг боловсрол, авьяас билиг, хүч хөдөлмөрийг Монголын сэтгүүл зүйн судлалд бүрэн зориулсан цөөхөн эрдэмтний нэг мөн.

мэдлэг мэдээлэлтэй ч ерээд онд Монголд нэг нийгэм нөгөөгөөр солигдож, барууны сэтгүүл зүйн шинэ уур амьсгал хүчтэй түрэн орж ирсэн зэргээс улбаатайгаар маргаан мэтгэл цээн үүсч, хэтэрхий мэргэн жараахайнууд олширч, туйлширч, мэдэмхийрэн цээжээ дэлдэцгээх нь хэрээс хэтрэх хандлагатай болж ирсэн эгзэгтэй түүхэн цаг үед Л.Норовсүрэнгийн "Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл" хэмээх шинжилгээ олон хүний толгойны эргээг гаргасан гавьяатай билээ.

Тогтмол хэвлэлийн хуудаснаа байнга гарч байдаг зарлал, мэдэгдэл, урилга, зурхай, зөвлөгөө, үгийн сүлжээ, шог яриа, онигоо, анкет, эмгэнэл, элэглэл, наргиа зэрэгт судлаач анхаарлаа хандуулан судалж, эдгээр нь сэтгүүл зүйн бичлэгийн "жижиг зүйлүүд" мөн гэж үзэн ангилж, агуулгаар нь төрөлжүүлсэн нь манай сэтгүүл зүйн судлалд цоо шинэ үг болсон юм.

**Гураа.** Доктор, профессор Л.Норовсүрэн 1996 онд "Редакторлах зүйн онол, дадлага" сурх бичиг хэвлүүлснээ 2008 онд өргөжүүлэн баяжуулж "Хянан найруулах ухаан" нэртэйгээр нийтийн хүртээл болгосон нь саяхныг хүртэл тус улсад үгүйлэгдсээр байсан ном хэвлэлийн онол, практикийн судалгааны хоосон орон зайлг нөхөж чадсан юм. Энэ нь сэтгүүлч боловсон хүчин бэлтгэж буй их, дээд сургуулиудын багш наарт редакторлах арга зүйн үндсийн үнэт хэрэглэгдэхүүн болсоор байгааг талархан тэмдэглэвэл зохино.

**Дөрөв.** Доктор, профессор Л.Норовсүрэн өөрийн эхлүүлсэн ариун үйлс, сэтгүүл зүйн судалгааны үйл ажиллагааг үргэлжлүүлэгч охин Н.Ариунзаяатай хамтран "Радио сэтгүүл зүй", "Телевизийн сэтгүүл зүй" хэмээх хоёр ном түүрвисан нь Монголын сэтгүүл

зүйн энэ чиглэлээрх ойлголт, онолын сэтгэлгээг хөгжүүлэхэд чухал тулхэц үзүүлсэн болно. Урьд нь М.Чойжилын "Агаар мандлын цэнхэр долгион" (1987), "Чихнээ чимэгтэй радио" (2004), Х.Наранжаргалын "Телевизийн сэтгүүл зүй: үндсэн ойлголт, зөвлөмж" (2006) зэрэг ном гарч байсан боловч радио сэтгүүл зүй, телевизийн сэтгүүл зүйн нарийн ширийнийг ингэж дэлгэрэнгүйгээр авч үзэж сурх бичгийн хэмжээнд түүрвисан нь үгүй юм.

**Н**эр дурдсан дээрх хоёр номдоо доктор Л.Норовсүрэн сэтгүүл зүйн өмнө тулгамдсан олон асуудлууд, түүний дотор иргэний сэтгүүл зүйн талаарх ойлголтод хангальтай хариулт өгсөн бөгөөд түүнийгээ өргөжүүлэн гүнзгийрүүлж Х.Энхтуяатай хамтран "Иргэний сэтгүүл зүй" ном түүрвисныг цохон тэмдэглэж байна.

**Тав.** Доктор, профессор Л.Норовсүрэнгийн сэтгүүл зүйн салбар дахь судалгаа нь нэг улс орны хүрээнээс аль хэдийн халин гарч, нийт монгол түүргатны хэмжээнд хүрчээ гэж үзэх бүрэн үндэслэл байна. Үүний жишээ нь түүний "ХХ зууны эхэн үеийн монгол сэтгүүлчид", "Монгол хуучин сонин сэтгүүлийн товч лавлах" ном юм.

**Зургаа.** Доктор, профессор Л.Норовсүрэн нь сэтгүүл зүйн сургалт судалгааны чиглэлээр бие даасан 38 ном, эрдэм шинжилгээний 100 шахам илтгэл, өгүүлэл түүрвиж, бусдын 20 гаруй номыг редакторлажээ. Тэрээр МУИС-ийн сэтгүүл зүйн тэнхимд 31 дэх жилдээ багшилж байна. Үүнээс Л.Норовсүрэн бол Монгол Улсад сэтгүүлийн мэргэжлээр боловсон хүчин бэлтгэхэд ухамсарт бүх амьдрал, оюун ухаан, авьяас билиг, хүч хөдөлмөрөө зориулсан сэтгүүл зүйн шинжилэх ухааны сургалтаар орлуулшгүй туршлагатай сурган хүмүүжүүлэгч мөн гэсэн

үнэлэлт дүгнэлтийг хийж болохоор байна.

Долоо Доктор, профессор Л.Норовсүрэн бол Монголын сэтгүүл зүйн нэрд гарсан том судлаач төдийгүй, манай туршлагатай сайн нийтлэлчдийн нэг юм. Тэрээр төв, орон нутгийн хэвлэлд нийтдээ 5000 гаруй мэдээ мэдээлэл, сурвалжлага, найруулал, тэмдэглэл нийтлүүлж, "Ус хөтөлсөн хүн", "Гурван түрэнд зорчсон тэмдэглэл" зэрэг ном хэвлүүлсэн нь үүнийг гэрчилнэ.

Үүн дээр Л.Норовсүрэн багш МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимд сэтгүүл зүйн мэргэжлийн өндөр хэмжээний түвшинд

фото лаборатори байгуулж, мянга мянган шавь нараа гэрэл зурагт мэргэшүүлсэн бөгөөд өөрийнхөө хэдэн зуун гэрэл зургийн бүтээлийг төв, орон нутгийн сонин, сэтгүүлд нийтлүүлснийг бас нэмж хэлэх нь зүйд нийцнэ.

**Д**октор, профессор Ломбын Норовсүрэн бол Монголын сэтгүүл зүйн судлалын нэрд гарсан том эрдэмтэн, судлаач, бусдад үлгэр дууриал үзүүлсэн сүмбэр ноён оргилуудын нэг бөгөөд манай туршлагатай сайн нийтлэлчдийн нэг яриа байхгүй мөн болно.